

**БАЙГУУЛЛАГЫН БАГА ҮНЭТЭЙ ТҮРГЭН ЭЛЭГДЭХ ЭД ЗҮЙЛС БОЛОН БУСАД
БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

Төмөрбулаг сум

№ 02

2019.02.18.

Нэг талаас Чандмань хүүхдийн цэцэрлэгийг төлөөлж Эрхлэгч ажилтай А.Амаржаргал
нөгөө талаас "Нарлаг цэнхэр далай" ХХК-ны захирал С. Лхагвамядаг нар харилцан
тохиролцож энэхүү гэрээг 1256700 төгрөгийн үнийн саналаар байгуулав.

Нэг: Ерөнхий зүйл

1.1. Монгол Улсын Иргэний хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр
бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, бусад хууль тогтоомжийн дагуу
олон нийтийн оролцоотойгоор бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдон
захиалагч нийлүүлэгчийн хооронд үүссэн харилцааг зохицуулах, харилцан хүлээх
үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
1.2 Гэрээ нь талууд гарын үсэг зурж баталснаар хүчин төгөлдөр болно.

Хоёр: Захиалагчийн эрх, үүрэг

2.1. Захиалагч нь нийлүүлэгчид сард захиалах бараа бүтээгдэхүүний нэр, тоо хэмжээг
сарын эхний 7 хоногт гаргаж өгнө.
2.2. Бараа бүтээгдэхүүний чанар стандарт, ашиглах хугацаа, зарлагын баримт,
нэхэмжлэлийн хамт тулган үзэж нярав хүлээн авч орлого авна.
2.3. Бүтээгдэхүүний төлбөрийг тухайн сард нь төлж барагдуулах
2.4. Захиалагч нь нийлүүлэгчээс гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, хугацаандаа
чанартай бараа бүтээгдэхүүн нийлүүлж байгаа эсэхэд хяналт тавих

Гурав: Бэлтгэн нийлүүлэгчийн эрх үүрэг

3.1. Нийлүүлэгч нь захиалагчийн өгсөн бараа бүтээгдэхүүний нэр, тоо хэмжээний дагуу
бараа бүтээгдэхүүнийг тогтоосон цаг хугацаанд нь нийлүүлнэ.
3.2. Захиалагчид бараа бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгөхдөө хүлээлгэн өгсөн зарлагын
баримт, нэхэмжлэлийг 2% үйлдэж няравт тоо хэмжээг тулган хүлээлгэн өгнө.
3.3. Чанарын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг нийлүүлж, үнийг тогтвортой
байлгана.
3.4. Захиалагч төлбөрөө хугацаандаа төлөөгүй тохиолдолд төлбөрийг нэхэмжлэх,
алданги тооцох
3.5 Захиалагч гэрээнд заасан бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэхээс гадна ганц нэгээр
цувуулж өгөхгүй байх

Дөрөв: Талуудын хүлээх хариуцлага.

4.1. Гэрээнд тусгасан үүргээ биелүүлж, гүйцэтгээгүй тохиолдолд гэм буруутай тал нь
нөгөө талдаа тухайн асуудлыг барагдуулж шийдвэрлэнэ.
4.2. Чанаргүй дутуу бараа үйлчилгээг нийлүүлэх, хүлээн авахыг хориглоно.

4.3. Захиалагч, нийлүүлэгч талууд хавсралтад заасан бараа бүтээгдэхүүнийг хүлээн авч, хүлээлгэн өгөх үүрэгтэй. Хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

Тав: Маргаан шийдвэрлэх

5.1. Энэхүү гэрээгээр үүссэн маргааныг талууд харилцан зөвшилцлийн замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Эс чадвал маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

5.2. Гэрээг 3 хувь үйлдэж нийлүүлэгч талд 1%-ийг өгнө.

Зургаа: Гэрээний үйлчлэх хугацаа.

6.1. Гэрээний үйлчлэх хугацаа: 2019 оны 02 сарын 18-аас 2019 оны 12 сарын 31-ныг хүртэл байна.

Долоо: БАТАЛГААЖУУЛАЛТ

Захиалагч:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Төмөрбулаг сумын
Цэцэрлэгийн эрхлэгч

.....*Амаржаргал*..... А.Амаржаргал

Утас 88263506, 99387105

Бэлтгэн нийлүүлэгч:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Төмөрбулаг сумын
"Нарлаг цэнхэр далай" ХХК-ны захирал


.....*С. Лхагвамядаг*..... С. Лхагвамядаг

Утас



Хүүхдийн цэцэрлэгт 2019 онд бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн
материалын жагсаалт

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо	Санал болгож үнэ	Нийт үнэ	Нарлаг цэнхэр далай ХХК-ий нийлүүлэх үнэ НБҮ	Нийт үнэ
1	Вок омо /том 800гр/	ш	50	5000	250,000	5000	250,000
2	Резин бээлий	ш	40	2500	100,000	2500	100,000
3	Барааны саван /популар/	ш	80	1000	80,000	1000	80,000
4	Ариутгалын бодис	х	4	55,000	220,000	55,000	220,000
5	Лампа	ш	11	1000	11,000	1000	11,000
6	Цагаан гэрэл	ш	10	5000	50,000	5000	50,000
7	Тогооны угаалтуур	ш	1	2600	2600	2600	2600
8	Гарын алчуур	ш	8	3500	28,000	3500	28,000
9	Уртасгагч	ш	5	15000	75,000	15000	75,000
10	Тоосны алчуур	ш	18	2000	36,000	2000	36,000
11	Шалны алчуур	ш	10	8000	80,000	6000	60,000
12	Тосгуур	ш	5	4000	20,000	4000	20,000
13	Хогийн шүүр /хатуу мяндсан/	ш	5	5000	25,000	5000	25,000
14	Хөл үрэгч	ш	5	10,000	50,000	10,000	50,000
15	Ширээний хулдаас	ш	15	5000	75,000	5000	75,000
16	Хувин /пивор/	ш	5	5000	25,000	5000	25,000
17	Өлгүүр	ш	20	2000	40,000	2000	40,000
18	Перий	ш	7	3500	24,5000	3500	24,5000
19	Аяганы порлон	ш	9	400	3600	400	3600
20	6 хос алчуур /сайн чанарын/	ш	3	4500	13,500	4500	13,500
21	Маарал	м	5	1500	7500	1500	7500
22	Аяга	ш	40	1000	40,000	1000	40,000
23	Халбага	ш	20	1000	20,000	1000	20,000
Нийт					1,276,700		1,256,700

Нарлаг цэнхэр далай ХХК-ий захирал:  С.Лхагвамядаг

